



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/142

Сүхбаатар сум

Хууль тогтоомж сурталчлах сургалт
зохион байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "д", 30 дугаар зүйлийн 30.1.6, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" үндэсний хөтөлбөр батлах тухай 50 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" аймгийн хөтөлбөр батлах тухай 154 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.5, 3.2.8 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг дахь Шүүхийн Тамгын газраас шинээр батлагдсан хууль тогтоомжоор иргэд, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулахад хөрөнгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, хууль, тогтоомж хөтөлбөрүүдийг сурталчлах ажлыг зохион байгуулахад шаардагдах 5.000.000 /таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

3.Зардлын тайланг гаргаж 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга /М.Нямсүрэн/-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ